



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/684

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн 30 дугаар цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 500,000.00 (таван зуун мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан биет бус хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Баянгол дүүргийн 30 дугаар цэцэрлэг (С.Нэргүй)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 500,000.00 (таван зуун мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий биет бус хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгахыг Баянгол дүүргийн 30 дугаар цэцэрлэг (С.Нэргүй)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *В.Оюумаа* В.ОЮУМАА



1150502008

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан		Хэмжээ хичээл	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын үнийн санал	НӨХТ-ийн мөргөжлийн дүгнэлт	УХХХК-ын хуурын тэмдэглэл
		глиж	5										
1	Веб программ		5	ш	1	500,000.00	500,000.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах	УХХХК-ын хуурын тэмдэглэл
Биет бус хөрөнгийн дүн													
Үүнээс: Худалдах хөрөнгө													
Актлах хөрөнгө													
Татан төвлөрүүлэх хөрөнгө													
Худалдсанаас олох орлого													
НӨХТ-т төвлөрүүлэх 30%													